

今月号は6ページ以降に素敵なお知らせが掲載されておりますので、ぜひぜひご覧下さい。

Буддын оюун ухааны ачаар зовлонгоос ангижрах нь

~12 учир холбоо ~



Бид яагаад будилан шаналдаг вэ? Үүнд 12 учир холбооны сургаал нь бидний өмнөх амьдралыг авч үзэн тайлбарлаж өгнө. Нэг харахад ойлгомжгүй юм шиг сургаал боловч товчлон тайлбарлахад “Бид бүхэн харанхуй мунхаг гэж нэрлэгдэх үндсэн мэдлэггүй байдлаасаа болж зовж шаналдаг юм. Эсрэгээр энэ харанхуй мунхагыг үгүй болговол зовлон ч алга болно” гэсэн утгатай юм.

12 учир холбоонд зовлонг:

1. харанхуй мунхаг, 2. үйл, 3. санаа, 4. дүр төрх, 5. зургаан орц, 6. хүрэх, 7. хүлээн авах, 8. хайр, 9. авах, 10. байх, 11. амь нас, 12. өтөлж үхэх гэсэн 12 үе шатаар хувааж, 1 үе шат нь дараагийн үе шатыг үүсгэдэг гэж заадаг байна.

Эхний шат болох харанхуй мунхаг гэдэг нь жинхэнэ үнэнийг мэдэхгүй учраас аливаа юмыг зөв харж чадахгүй байдлыг хэлдэг байна. Ийм байдалтай хүний үйлдэх үйл нь мэдээж хэрэг жинхэнэ үнэнээс хол үйл болж таарна. Тэр нь дараагийн шатын үйл болдог байна.

Дараагийн шатын Санаа гэдэг нь ухаан санааг хэлж байгаа билээ. Буддын шашинд хүн эхийнхээ хэвлийд анх дөнгөж үр болж орсон тэр мөчөөс эхлэн хүн болдог гэж үздэг байна. Яг тэр мөчөөс хүн ухаан санаатай болдог бөгөөд тэр ухаан санаа нь уг хүний өмнөх насандаа хийсэн үйлд нь таарсан байдаг гэдэг.

Эхийнхээ хэвлийд олсон тэр амь нь ухаан санаандаа тааруулж бие сэтгэлээ хөгжүүлдэг байна. Тэр нь Дүр Төрх юм. Дүр төрх нь хөгжөөд ирэхлээр цаашид нүд, чих, хамар, хэл, хүрч мэдрэхүйн таван мэдрэхүй ба сэтгэл хөгждөг байна. Эдгээр нь Зургаан Орц болдог байна.

Ийнхүү хүн энэ ертөнцөд төрөөд юмыг мэдэрч ангилдаг болдог (хүрэх). Түүнчлэн дуртай, дургүй, баяртай, гунигтай, хөгжилтэй, зовлонтой гэх мэтийн сэтгэлийн мэдрэмжтэй болдог (хүлээн авах). Мөн дуртай юмандаа автагддаг болдог (хайр) ба түүнийгээ өөрийнхөө өмч болгох гэж эсвэл эсрэгээр дургүй юмнаасаа ангижрах гэж хүсдэг байна (авах).

“Авах” байвал хүн бусдаас өөрөөр сэтгэж боддог байна. Энэ нь “байх” гэсэн шатыг төрүүлж, улмаар бусадтай тэмцэх, өрсөлдөх байдал төрж зовлон эхэлдэг байна. Энэ бол хүний амьдралын “амь нас” бөгөөд эцэст нь “өтөлж үхэх” гэсэн хүний том зовлон ирдэг байна.

Ийнхүү бүх юм харанхуй мунхагаас эхэлж дараа дараагийн 11 зовлонгийн үе шат үргэжлэн эцэст нь зовлонгоор дүүрсэн амьдрал өнгөрөөх болдог байна.

Эсрэгээр эдгээр үе шатыг үгүй болгохын тулд харанхуй мунхагыг үгүй болгох хэрэгтэй гэж уг сургаал нь заадаг байна.

Энэ харанхуй мунхагыг чухам яаж үгүй болгох вэ? Харанхуй мунхаг гэдэг нь энэ ертөнцийн жинхэнэ үнэнийг мэдэхгүй, эсвэл тэр үнэнийг үл тоосон буюу буддын шашны хэллэгээр оюун ухаангүй байдал гэсэн үг учраас эсрэгээр оюун ухаантай болвол зовлонгоос ангижрана гэсэн утга билээ. Өөрөөр хэлбэл, Буддын сургаалыг биелүүлж, сургаалын оюун ухааныг эзэмших байдлыг хэлнэ.

Мэдээж хэрэг Буддын оюун ухааныг эзэмшинэ гэдэг бол тийм ч амар зүйл биш. Гэвч бага багаар ч болон хичээж, аажим аажмаар мунхагаа үгүй болгох нь чухал юм.

Дөрвөн сэтгэл, Зургаан барамид гээд янз бүрийн сургаалыг биелүүлснээр бид нэг нэг алхамаар Буддын оюун ухаанд ойртож байгаа юм.

12 Essentials for Good Living

ЭХИЙН СЭТГЭЛЭЭСЭЭ ХУВААЛЦАЯ

Рисшо Косей-Кайгын ерөнхийлөгч
Нивано Ничикоү

Энэрэнгүй сэтгэл хаягдаж байна

Өдий хүртэл би энэ талаар хэд хэдэн удаа ярьсан билээ. Өнөөгийн ертөнцөд аливаа юмыг хурдан бөгөөд онолын дагуу л хийвэл сайн гэж үнэлэгддэг билээ. Мэдээжийн хэрэг үүнд олон хүнд тус нэмэр болох зүйл их бий. Гэвч зөвхөн эдийн засгийн талыг л давуугаар үзсэнээр энэрэнгүй сэтгэл, хүнийг хайрлан бодох сэтгэлийг үл тоож орхиж байгаа юм шиг санагддаг. Мөн хар багаасаа зөвхөн хичээл шалгалтанд бэлтгэгдэж, ажлын суурь булаалцахын төлөө өссөн хүмүүсийн дунд энэрэнгүй зөөлөн сэтгэлтэй хүмүүс байр сууриа олж чадахгүй гэвддэг.

Өөрөөр хэлбэл, ашиг хонжооны төлөө зүтгэсний эцэст бид хүмүүс хүний хувьд хамгаас чухал байдаг хүнлэг сэтгэлээ орхин хаяснаас сэтгэлийн шархтай хүн ихээр олширч байгаа билээ.

Ийм байдлыг зогсоохын тулд бид “эхийн сэтгэлийг” эргэн санах хэрэгтэй.

Эхийн сэтгэл гэж юуг хэлдэг вэ? Эхийн сэтгэл ямар байдаг вэ? гэж бодож байх үед хүнийг хайрлах арга зам харагдана.



Ямар ч эрх ашгийг боддоггүй эхийн хайр шиг

Энэ оны 6 сард Өмнөд Африкт хөл бөмбөгийн Олон Улсын тэмцээн зохиогдсон билээ. Японы хөл бөмбөгийн бүлгийг мэдэх хүн олон байгаа байх. Тэр бүлгийн нэг гишүүн нь дүрэм зөрчсөний улмаас тоглолтоос хасагдсан билээ. Тэмцээн дууссаны дараа нулимсаа асгаруулан уйлах тэр тамирчин дээр бусад тамирчид очиж мөрөө тэврэлдэн бүгд хамтдаа

уйлах тэр агшин мартагдашгүй билээ.

Эхийн сэтгэл гэхээр заавал зөвхөн эмэгтэй хүнд л байдаг өвөрмөц хайр вч шиг санагдах боловч үнэндээ бол эхийн сэтгэл нь хүн бүрт байдаг зүйл юм. Алдаа дутагдлыг нь буруутгалгүй зовж шаналсан андынхаа дэргэд очиж, хамт зовлонгийг нь хувааж уйлж зогсох тэрхүү үйлд хүний зовлонг чин сэтгэлээсээ ойлгох сэтгэл, хүнийг үггүйгээр сэтгэлээр дэмжих явдал, амьдрах эр зориг, хүч чадал олгож өгөх яг л эхийн мэт зөөлөн энэрэнгүй сэтгэлийг тэр тэмцээнээс олж харсан юм.

Манай Үүсгэн Байгуулагч эгч нарыг бага байхад нь “энд өвдөөд байна” гэхээр нь гараа тэр өвдсөн хэсэгт нь тавьж, тайвшруулдаг байсан гэдэг. Бага зовлонг ч гэсэн шууд тайлж, хүнд амгалан тайвныг олгох энэхүү жижигхэн үйл явдалд ч эхийн энэрэнгүй сэтгэл харагдана.

Зовж ядарсан хүнд хариу байхгүй ч гараа тосч тусалж, бусдын зовлонг өөрийн мэт хүлээн авч, хүмүүсийг дэмжин тусалж, хүүхдээ хайрлах эхийн хайр шиг хүмүүсийг хайрлан нандигнах хэрэгтэй.

Ийм эхийн хайр шиг сэтгэлээ нандигнан хайрлаж, дэлхийн бүх хүмүүс тийм сэтгэлтэй болж чадахын төлөө бид буддын сургаалаа өдөр тутмынхаа амьдрал дээрээ биелүүлэн байж, цаг хугацааны мөч бүрийг хайрлан, юуны өмнө ойр дотныхоо хүмүүсээ хайрлан хүндэтгэе.

Гэвч зарим үед чухал зүйлийг ойлгуулахын тулд эцгийн хатуу сэтгэлийг ч харуулах хэрэгтэй үе байдаг.

Цагаан Лянхуа Цэцгийн сударт гал түймэрт нэрвэгдсэн хүүхдүүдээ эцэг нь өөрийн гараар авралгүйгээр, тэд өөрсдөө амиа аврахын төлөө гэрээс зугтахыг зөвлөдөг үйл явдал бичигдсэн байдаг. Ийнхүү шууд өөрөө аврах биш, хүн өөрөө санаж сэтгэж, аврагдах арга замаа олохын тулд зарим үед эцгийн хатуу гар хэрэгтэй болдог байна.

Гэвч ямар ч үед ч хүн бусдын зовлонд сэтгэл тавьж, нигүүлсэхүй сэтгэлээ гаргаж байх ёстой.

“Косэй” 2010 оны 10 сар





Буддагийн ивээл дор 3

салбарын дарга Киношита Томоак Кобэ нийгэмлэг

Энэхүү яриа нь 2010 оны 4 сарын 11-нд Кобэ нийгэмлэгийн 60 жилийн ойн баярт зохиогдсон юм.3 хэсэгт хувааж танилцуулья.

“Бид дэлхий дээр ганцаархнаа биеэ даагаад амьдардаггүй.Хүний төлөө өөрийн хийж чадах буянтай сайн үйлдлээ хийж бай” гэж заалгасан юм.Энэ бол үнэхээр гүн утга учиртай зүйл боловч “одоохон үхэх гэж байгаа надад ямар юм хийж чадах вэ?” гэж бодогдсон билээ.Үнэндээ ч хорт хавдар маань нурууны яс,тааз,хэвлий үрүү хүртэл шилжиж тарсан байв.Эмчилгээ ч үүгээр аргаа барж байлаа.Шинэ эмчилгээний төлөө 10 сард эмнэлэгт хэвтэж,өдий болтол амсаж үзээгүй эмчилгээний дагавар нөлөөний өвдөлтийг тэсэн зовж байв.

Тэр үед 11 сарын “Якүшин” сэтгүүлд бичигдсэн Үүсгэн Байгуулагчийн үг нүдэнд туссан юм.”Зөвхөн нүдэнд харагддаг зүйлийг л буян гэдэггүй юм.Буянтай үйлийг бага багаар хурааж авсан өөрөө өөртөө баярлаж,цэлмэг тэнгэр шиг сэтгэлээр өдөр бүрийг өнгөрөөж байх нь буяны хамгийн их том ач юм.Чин сэтгэлээрээ үнэнчээр амьдарч байвал хэн ч гэсэн “энэ хүн бол үнэхээр үнэнч хүн шүү” гэж итгэж,чухал ажил үүргийг ч даалгах болно.Мөн бас нэгэн чухал зүйл бол өдөр бүр учирдаг бүх үйл явдал нь Буддагаас илгээсэн тушаал гэж бодон чин сэтгэлээсээ талархаж хүлээн авах явдал юм.Өөрийнхөө ядуу толгойгоор энэ тэрээ гэж бодож,зоволгүйгээр бүхнийг гэгээрсэн Буддад даалгаж,өөрийнхөө хийж чадах зүйлээ л сайвтар хийж байвал хичнээн амар гээч.Бурханд даалгаж орхино гэдэг бол Агуу Их Амгалан юм”

Энэ үгийг уншаад би өөрийгөө хаана ч байсан ч хүний төлөө ямар нэгэн юм хийж чадах юм байна гэсэн эр зориг,амьдрах хүсэл төрсөн юм.Орчин тойронд хандах үзэл бодол ч өөрчлөгдсөн.Хүмүүсийн тус дэмжлэгийг сэтгэлийн ачаа мэт хүлээж авдаг байсан бол үүнд чин сэтгэлээсээ талархаж чаддаг болсон.Энэ сургаал бол толгойгоороо бодох биш үйлээр хийж сурах зүйл юм.

Үүсгэн Байгуулагч Цагаан Лянхуа Цэцэгийн Сургаалын тухай ингэж өгүүлсэн билээ:” Цагаан Лянхуа Цэцэгийн Сургаал нь маш хүнлэг утга учиртай.Сэтгэц сэтгэл нь хүнлэг.Мөн энэ сургаалыг үйлдэж хийх явдал нь хүнлэг юм.Сургаалыг ойлгож,итгэж,биелүүлснээр нийгмийн жирийн амьдралыг өнгөрүүлэнгээ янз бүрийн зовлон шаналгаанд автагддаггүй сэтгэлтэй болж хувирана.Хүмүүстэй найрсаг болж,хүний төлөө гэсэн сэтгэл тэмүүлэлтэй болно.Өдрийн хэдэн цаг ч гэсэн хүн иймэрхүү сэтгэлтэй болбол тэр хүний эрүү мэнд,орчин нөхцөл өөрийн эрхгүй өөрчлөгдөж

эхлэнэ.Энэ л чухам жинхэнэ аврал мөн.Дэлхийн бүх хүн ийм сэтгэлтэй болбол бүгд аз жаргалтай,энх амгалан амьдрах болно.Энэ бол Цагаан Лянхуа Цэцэгийн Сургаалын хамгийн том хүсэл зорилго юм.”

Би одоо үнэхээр аз жаргалтай байна.Амьдрал дээр бол хүн өвчин тусахад ямар сайн байхав гэж боддог боловч би тэгж бодохгүй.Хүн бол төрсөн цагаасаа авахуулан хөгширч,өтөлж,өвдөж үхдэг.

Энэ өвчнийхөө ачаар янз бүрийн хүмүүстэй уулзаж учирлаа.Олон ч юм сурлаа:амьдралын нандин мөн чанар,амьдрах утга учир,уялдаа холбооны хүнлэг чанарыг ойлгосноос гадна хамгийн гол нь хичнээн сайхан гэр бүлтэй байснаа ухаарч чин сэтгэлээсээ баярлан талархаж байна.Мөн сургаалдаа итгэж,бага ч гэсэн биелүүлэхийг хичээх болов.

Хорт хавдар маань биеэр тархаж байгаа ч би одоо ийнхүү амьд явж байна.Зүгээр нэг амьд байгаа биш та бүхэнтэйгээ хамт Буддагийн ивээл дор амьдарч байна.Үүнийг би сайн мэдэрч байна.Надад хийж чадах зүйлс их байна.Зоригтойгоор амьдрах зорилготой байна.

Миний мөрөөдөж байсан мөрөөдөл маань ч ийнхүү өнөөдөр биеллээ.Та бүхний дэргэд яриагаа дэлгэж ярьж чадлаа.Будда ба та бүхний ач буян юм.Би одоо дараагийнхаа мөрөөдлөө биелүүлэхийн төлөө амьдрана.

Будда,Үүсгэн Байгуулагч,Ерөнхийлөгч ба та бүгдэд чин сэтгэлээсээ баярлан талархаж байна.

Төгсөв.

Киношита нь өвчинтэйгээ удаан тэмцэсний эцэст 2010 оны 9 сарын 19 өдөр нас эцэслэв. Амгалан нойрсож, бурханы оронд залрах болтугай.



Буян ганцаарддаггүй

Буян бол ганцаарддаггүй, хажууд нь заавал хөрш байдаг гэсэн зүйр цэцэн үгийг нэгэн мэргэн хүн хэлсэн билээ. Өөрөөр хэлбэл, буян үйлдэж явдаг хүн хэзээ нэгэн цагт өөрийг нь ойлгож, дэмжиж өгөх хүнтэй заавал учирдаг гэсэн утгатай юм.

Хүмүүс бид ямар нэгэн сайн үйл хийж, бусдад магтуулж үнэлэгдэхгүй л бол “ерөөс яршиг яршиг” гээд больдог билээ. Гэвч чимээгүй сайн үйл хийж, буян хурааж байвал харах ёстой хүн нь харж л байдаг юм. Хамгийн гол нь хэн нэгэнд үзүүлж харуулах биш харин өөрөө ийм буян хийх гэсэн сэтгэлтэй болсондоо бас тийм

завшаантай болсондоо баярлан талархах хэрэгтэй юм.

Дэлхийн Шашны Энх Тайвны Хурал болоход мөн л өөрийнхөө хийх ёстой буяны үйл ажиллагаагаа хийж л байвал энх тайвны төлөө хамтран зүтгэх хүн заавал гарч ирдэг байна. Та бүгдийн дунд ч иймэрхүү туршлагатай хүн багагүй бий байх.

Шагжамүни ч ингэж хэлдэг байв: “Буян хийдэг хүн чимээгүй буланд сууж байсан ч түүний нүүр гялалздаг юм. Орчин тойрны хүмүүс өөрийн эрхгүй түүнд татагддаг”.

-Үндэслэгчийн үг* Косэй хэвлэл, 78-79х

*** Column ***


Энэ жилийн “Оэшики” баярын үйл ажиллагаа нь 10 сарын 3-ны ням гаригт болох бөгөөд гадаадаас Бразил, Монгол, Тайван, Бангладеш орноос 63 төлөөлөгч нар оролцоно. Уг баярын утга нь Агуу Их Багш Ничирэны ариун үйлийг дурсаж, хүнийг аварч, дэлхийг засна гэсэн зорилготой байдаг байна. Агуу Их Багш Ничирэн манай нийгэмлэгийг үүсгэн босгож байх үед Японд байгалийн элдэв гай гамшиг байнга болж, зам дээр үхэр морьтой хамт зэрэгцэн олон хүн өлсөж үхэн хэвтэж байсан билээ. Тэр үеийг даван туулахын тулд хүнд шашин сүсэглэл зайлшгүй

хэрэгтэй гэж бодсон Ничирэн Багш хүмүүст: “Хүн бүр хурдан сүсэглэлийн сэтгэлээ олъё” гэж уриалж байсан юм. Энэ онд ч дэлхийн энд тэнд байгалийн гай гамшиг үүсч байна. Пакистаны үерд 200 сая хүн хохирсон байна. Эргэн засах үйл ажиллагаа нь одоо хүртэл сайн явагдаж эхлээгүй л байгаа сурагтай. Оросод хуурайшлаас болж 700 гаруй уулын гал түймэр болсон байна. Дэлхийн ийм байдлыг харахад одоо хүн төрөлхтөний жинхэнэ сүсэглэлийн үе нь ирсэн юм шиг санагдах юм. Косэйкайгийн гишүүд бидний жинхэнэ үйл ажиллагаа эхлэх цаг ирлээ.

(Kotaro Suzuki)

Ришшэ Косэйкайгийн тухайд

Ришшэ Косэйкай бол 1938 онд Үүсгэн Байгуулагч Нивано Никкё ба Наганума Мёко санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Уг байгууллага нь “Лянхуа цэцэгийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, гэр орондоо шүтэх шашины нэгэн шинэ хэлбэр ба сургаалийг амьдрал ахуй, нийгэмдээ хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайваныг зорьж байгаа юм.



SHAN-ZAI 2010 он 10 сар (Vol.61)

【Үүсгэн гаргагч】 Ришшэ Косэйкай Олон улсын салбар Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, 166-8537 Japan TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail: shanzai@kosei-kai.or.jp
 Редактор: Огивара Туслах: Ms. Shiko MATSUOKA Editorial Staff: Ms. Chika IKEBUCHI, Ms. Akiko IMAFUJI, Ms. Yukino KUDO and Ms. Kaoru SAITO

※Энэхүү сэтгүүл нь япон, англи, хятад, солонгос хэл дээр гардаг бөгөөд зарим дугаарууд нь бусад хэл дээр бас гардаг юм. ※Санаа сэтгэгдэл байвал холбоо барина уу. ※Мөн хувийн зорилгоор ашиглах үед Олон улсын салбар луу холбоо барина уу s.

Live Broadcasting on Web

Annual Memorial Day Of Founder's Nirvana 開祖さま入寂会



Oeshiki-Ichijo Festival お会式・一乗まつり

インターネット配信のお知らせ

Oeshiki-Ichijo Festival will be held on 3 October, and Annual Memorial Day of Founder Nikkyo Niwano's Nirvana is on 4 October 2010. These two ceremonies which will be held at Headquarters in Tokyo will be broadcast through Internet this year.

Oeshiki-Ichijo Festival

3 October Starts at 1:30 p.m. by Japanese Time.
The festival will be broadcasted in both English and Japanese.

Annual Memorial Day of Founder's Nirvana

4 October Starts at 9:00 a.m. by Japanese Time.
The ceremony will be broadcasted in both English and Japanese.

We are looking forward to your participation in the ceremonies!

If you have any questions, please contact
Ms. Imafuji, Rissho Kosei-kai International.

[E-mail address; akiko.imafuji@kosei-kai.or.jp](mailto:akiko.imafuji@kosei-kai.or.jp)

※Oeshiki Ichijo festival takes the form of a lantern-parade, which commemorates and honors Nichiren; expresses our respect, acclaim and gratitude towards Founder Niwano; and seeks to reaffirm our determination to further practice the bodhisattva way.

10月3日はお会式・一乗まつり、10月4日は開祖さま入寂会です。今年はその模様をインターネットを通じて配信します。時間と配信言語は以下の通りです。

【お会式・一乗まつり】

10月3日 午後13:30開始(日本時間)
配信言語:日本語と英語

【開祖さま入寂会】

10月4日 午前9:00開始(日本時間)
配信言語:日本語と英語

全世界からの本式典へのご参加を心よりお待ちしております。

ご不明な点は、国際伝道本部今藤までお問い合わせ下さい。

[お問い合わせ先; akiko.imafuji@kosei-kai.or.jp](mailto:akiko.imafuji@kosei-kai.or.jp)

※お会式一乗まつりとは

日蓮聖人の遺徳を偲び、開祖さまを追慕、讃嘆、報恩感謝し、菩薩行実践への決意を新たにすることを目的として毎年開催されている万灯行進です。

Instruction to participate in Ceremony for Annual Memorial Day of Founder's Nirvana

Dear All,

Ceremony for Annual Memorial Day of Founder's Nirvana will be held on October 4, 2010. Using WebEx; meeting system on the web, overseas branches can participate in the ceremony at each place. Please find the following instruction.

1. Activating web browsing application and connecting to <https://kosei-kai.webex.com>.
The site named "Rissho Kosei-Kai WebEx Enterprise Site" shall be opened.



2. You can find two topics of meeting in the "Browse Meetings" in this site.
We prepare two meetings for Japanese and English.
Choose whichever you want to join and click "Join now."

Browse Meetings

Search for: All meeting times in: [Japan ST](#)


(Type host name, meeting topic, or any text in agenda)

Today **Daily** Weekly Monthly


◀ Saturday, September 13, 2008 ▶

Time	Topic	Host	Duration	Status
5:00 pm				
5:25 pm	Annual Memorial Day of Founder's Nirvana-English	Ken NAGATA	1 hour	Join now
5:28 pm	Annual Memorial Day of Founder's Nirvana-Japanese	koichi kawamoto	1 hour	Join now


3. Please provide your information; 1. Your name, 2. Email address, 3. Meeting password.
The meeting password is as follows. "founder"
And then, click "OK." And click "Yes" if the security warning dialog box appears.



4. When the meeting starts, the dialog box of "Join Integrated VoIP" appears.
Please click "Yes". You can hear the sound and voice.
5. You can find a video in the window, and there are two buttons under the video.
Left button is for "Full-screen," and right one is for "View Floating Video Window."
If you want to watch the video in large size, please click these buttons.



6. Right side of the window of this meeting, you can find the panel of "Chat."
If you have any troubles or questions in the meeting, please let us know through the chat.
We will reply soon through chat.



Rissho Kosei-kai Overseas' Dharma Centers

2010

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@buddhistcenter-rkina.org <http://www.buddhistcenter-rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
www.rkina.org/tampabay

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@mail.rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Branch

73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96750, U.S.A.
Tel & Fax: 1-808-325-0015

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rk-la.com>

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: tozuna48@yahoo.com

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Denver

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-5569
e-mail: rkksf@sbcglobal.net

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle

851 N San Mateo Dr, San Mateo, CA 94401, U.S.A.

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami3370@hotmail.com

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls

724 Main St. Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

4340 E Kentucky Ave #345 Glendale CO 80234, U.S.A.
Tel: 1-303-319-2765 Fax: 1-720-876-4534

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: hiromi_mat@yahoo.com <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No.10 Hengyang Road, Zhongzheng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No.19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilong

Rissho Kosei-kai of Tainan

No.45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

No.4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic
of China
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, the Russian Federation
Tel & Fax: 7-4242-43-78-56

Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
Tel: 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053
e-mail: rkkgva@wcc-coe.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy
Tel: Contact to *Rissho Kosei-kai (Geneva)*

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
Tel: Contact to *Rissho Kosei-kai (Geneva)*

Rissho Kosei-kai of Sydney**Rissho Kosei-kai of Singapore****International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibt-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel/Fax: 880-31-2850238

Rissho Kosei-kai of Dhaka

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
Tel: 880-2-8316887

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel: 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle

"Suwisal" Bataganwila, Imaduwa, Sri Lanka

Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division**Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Other Groups**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

114, Nanshi Si Road, Zenruzhen, Putuo-qu, Shanghai, China